АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Татварын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** АРА-2025/21/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас www.Open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор Н.Энхчимэг<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Enkhchimegn@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 76

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЭРДЭНЭБИЛЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Татварын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд татвар хураалт, орлого бүрдүүлэлт хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр улсын төсвөөс 2,128,233.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 2,112,288.6 мянган төгрөг зарцуулж, улсын төсөвт 15,944.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 үндсэн зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Татварын ерөнхий газарт хүргүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 54,345,016.61 | 34,205,595.74 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 20,080,000.00 | 15,240,000.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 20,080,000.00 | 15,240,000.00 |
| 3121 | Төгрөг | 20,080,000.00 | 15,240,000.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 20,080,000.00 | 15,240,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 34,265,016.61 | 18,965,595.74 |
| 354 | Хангамжийн материал | 34,265,016.61 | 18,965,595.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 824,000.00 | 521,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 32,713,546.61 | 17,505,671.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 701,510.00 | 914,284.74 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 25,960.00 | 24,640.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 392,720,303.37 | 349,026,950.26 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 392,720,303.37 | 349,026,950.26 |
| 392 | Биет хөрөнгө | 363,510,303.37 | 319,816,950.26 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 287,254,097.44 | 287,254,097.44 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -60,997,368.00 | -72,347,423.84 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 104,000,000.00 | 104,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -61,126,655.57 | -71,549,025.29 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 239,945,844.98 | 238,883,693.12 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -146,431,519.34 | -167,176,125.64 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 28,522,712.00 | 26,563,108.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,656,808.14 | -25,811,373.53 |
| 393 | Биет бус хөрөнгө | 29,210,000.00 | 29,210,000.00 |
| 39301 | Програм хангамж | 309,611.72 | 309,611.72 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -309,611.72 | -309,611.72 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 29,210,000.00 | 29,210,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 447,065,319.98 | 383,232,546.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 447,065,319.98 | 383,232,546.00 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 447,065,319.98 | 383,232,546.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 541,027,994.00 | 541,027,994.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 541,027,994.00 | 541,027,994.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -96,742,653.49 | -160,575,427.47 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -50,489,407.16 | -96,742,653.49 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -46,253,246.33 | -63,832,773.98 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,779,979.47 | 2,779,979.47 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 447,065,319.98 | 383,232,546.00 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,688,720,717.51 | 2,258,817,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 30,816,501.51 | 35,387,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 30,816,501.51 | 35,387,000.00 |
| 120009 | Бусад орлого | 29,528,715.51 | 35,237,000.00 |
| 120010 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,287,786.00 | 150,000.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,657,904,216.00 | 2,223,430,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,652,537,000.00 | 2,128,233,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,652,537,000.00 | 2,128,233,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 5,367,216.00 | 95,197,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,367,216.00 | 10,645,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 84,552,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,734,853,903.84 | 2,321,186,496.78 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,734,853,903.84 | 2,321,186,496.78 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,550,232,036.33 | 2,139,684,385.79 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,123,808,895.06 | 1,642,322,960.84 |
| 210101 | Үндсэн цалин | 546,626,392.42 | 776,013,839.37 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 217,389,859.27 | 439,349,503.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 68,095,148.10 | 67,296,000.00 |
| 210104 | Урамшуулал | 291,697,495.27 | 359,663,617.82 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 159,540,879.06 | 204,858,185.13 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,804,481.27 | 139,883,404.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,051,825.66 | 16,361,008.68 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгал | 8,986,059.23 | 8,117,803.95 |
| 210204 | Ажилгүйдлын даатгал | 3,258,513.85 | 8,038,977.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,439,999.05 | 32,456,990.06 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 45,601,326.00 | 44,755,202.33 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 2,200,000.00 | 2,419,880.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,406,400.00 | 40,406,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,994,926.00 | 1,928,922.33 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,184,026.40 | 45,036,680.87 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,577,420.00 | 6,708,890.00 |
| 210402 | Тээвэр шатахуун | 4,870,681.00 | 10,022,825.26 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 3,890,665.40 | 4,038,801.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,545,260.00 | 23,966,164.61 |
| 2105 | Нормативт зардал | 0.00 | 578,900.00 |
| 210503 | Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 578,900.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,355,100.00 | 17,194,300.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 0.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,355,100.00 | 15,594,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,167,200.00 | 18,032,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,167,200.00 | 18,032,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 83,269,992.97 | 96,572,480.71 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 77,308,000.97 | 95,523,417.71 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 873,200.00 | 877,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,582.00 | 147,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,880,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 17,210.00 | 2,381.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 68,304,616.84 | 70,333,675.91 |
| 210902 | Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх | 1,480,150.00 | 4,901,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал | 66,824,466.84 | 65,431,875.91 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 184,621,867.51 | 181,502,110.99 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 93,870,500.00 | 165,325,700.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 17,482,000.00 | 16,840,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 69,488,500.00 | 0.00 |
| 213208 | ХОН-т тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 143,685,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,900,000.00 | 4,800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 90,751,367.51 | 16,176,410.99 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90,751,367.51 | 16,176,410.99 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | -46,133,186.33 | -62,369,296.78 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 120,060.00 | 1,463,477.20 |
| 225001 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 120,060.00 | 1,463,477.20 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -120,060.00 | -1,463,477.20 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | -46,253,246.33 | -63,832,773.98 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | 1,677,939,216.00 | 2,235,465,200.00 |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | 20,035,000.00 | 12,035,000.00 |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 20,035,000.00 | 12,035,000.00 |
| 120009 | Бусад орлого | 20,035,000.00 | 12,035,000.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | 1,657,904,216.00 | 2,223,430,200.00 |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,652,537,000.00 | 2,128,233,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,652,537,000.00 | 2,128,233,000.00 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,367,216.00 | 95,197,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,367,216.00 | 10,645,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 84,552,200.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,668,588,652.00 | 2,240,305,200.00 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,668,588,652.00 | 2,240,305,200.00 |
| 210 | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,483,966,784.49 | 2,059,035,081.76 |
| 2101 | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,141,558,496.68 | 1,642,469,615.79 |
| 210101 | Үндсэн цалин | 546,626,392.42 | 776,013,839.37 |
| 210102 | Нэмэгдэл | 235,139,460.89 | 439,555,719.80 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 68,095,148.10 | 67,296,000.00 |
| 210104 | Урамшуулал | 291,697,495.27 | 359,604,056.62 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 141,791,277.44 | 204,943,522.93 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 96,804,481.27 | 139,883,404.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,302,224.04 | 16,370,962.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,986,059.23 | 8,122,780.18 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,247,964.85 | 8,103,515.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,450,548.05 | 32,462,860.72 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,601,326.00 | 44,755,202.33 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,200,000.00 | 2,419,880.00 |
| 210302 | Түлш, халаалт | 40,406,400.00 | 40,406,400.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,994,926.00 | 1,928,922.33 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 18,777,141.40 | 26,831,660.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,039,300.00 | 4,900,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,547,216.00 | 10,235,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,890,665.40 | 3,996,891.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 300,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,999,960.00 | 7,399,169.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,842,000.00 | 17,207,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 0.00 | 1,600,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,842,000.00 | 15,607,300.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 7,167,200.00 | 18,032,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,167,200.00 | 18,032,000.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 86,239,192.97 | 99,817,480.71 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 80,157,200.97 | 98,768,417.71 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 873,200.00 | 877,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,582.00 | 147,582.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,000,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 17,210.00 | 2,381.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,990,150.00 | 4,978,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,990,150.00 | 4,978,300.00 |
| 213 | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 184,621,867.51 | 181,270,118.24 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 93,870,500.00 | 165,325,700.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 17,482,000.00 | 16,840,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 69,488,500.00 | 0.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтэй ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 143,685,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,900,000.00 | 4,800,000.00 |
| 2133 | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 90,751,367.51 | 15,944,418.24 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90,751,367.51 | 15,944,418.24 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 9,350,564.00 | -4,840,000.00 |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 9,350,564.00 | -4,840,000.00 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 12,600,000.00 | 20,080,000.00 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 20,080,000.00 | 15,240,000.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 4-01 | 2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 541,027,994.00 | 2,779,979.47 | -50,489,407.16 | 493,318,566.31 |
| 4-03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 541,027,994.00 | 2,779,979.47 | -50,489,407.16 | 493,318,566.31 |
| 4-08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -46,253,246.33 | -46,253,246.33 |
| 4-01 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 541,027,994.00 | 2,779,979.47 | -96,742,653.49 | 447,065,319.98 |
| 4-03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 541,027,994.00 | 2,779,979.47 | -96,742,653.49 | 447,065,319.98 |
| 4-08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -63,832,773.98 | -63,832,773.98 |
| 4-01 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 541,027,994.00 | 2,779,979.47 | -160,575,427.47 | 383,232,546.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,128,233,000.00 | 2,112,288,581.76 | 15,944,418.24 | 99.3 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,128,233,000.00 | 2,112,288,581.76 | 15,944,418.24 | 99.3 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,981,907,300.00 | 1,966,237,881.76 | 15,669,418.24 | 99.2 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,580,659,100.00 | 1,568,645,434.79 | 12,013,665.21 | 99.2 |
| Үндсэн цалин | 684,442,300.00 | 776,013,839.37 | -91,571,539.37 | 113.4 |
| Нэмэгдэл цалин | 413,533,400.00 | 365,731,538.80 | 47,801,861.20 | 88.4 |
| Унаа хоолны Хөнгөлөлт | 81,269,600.00 | 67,296,000.00 | 13,973,600.00 | 82.8 |
| Урамшуулал | 401,413,800.00 | 359,604,056.62 | 41,809,743.38 | 89.6 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 197,231,600.00 | 195,715,503.93 | 1,516,096.07 | 99.2 |
| Тэтгэврийн даатгал | 135,752,800.00 | 133,642,316.45 | 2,110,483.55 | 98.4 |
| Тэтгэмжийн даатгал | 15,369,600.00 | 15,620,720.16 | -251,120.16 | 100.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 7,684,900.00 | 7,747,660.18 | -62,760.18 | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 7,684,900.00 | 7,728,395.11 | -43,495.11 | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 30,739,400.00 | 30,976,412.03 | -237,012.03 | 100.0 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 46,206,500.00 | 44,755,202.33 | 1,451,297.67 | 96.9 |
| Гэрэл, цахилгаан | 2,600,000.00 | 2,419,880.00 | 180,120.00 | 93.1 |
| Түлш, халаалт | 40,406,500.00 | 40,406,400.00 | 100.00 | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 3,200,000.00 | 1,928,922.33 | 1,271,077.67 | 60.3 |
| Хангамж, бараа материалын зардал | 25,500,000.00 | 25,496,060.00 | 3,940.00 | 100.0 |
| Бичиг хэрэг | 4,900,000.00 | 4,900,000.00 | 0.00 | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 8,900,000.00 | 8,900,000.00 | 0.00 | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,000,000.00 | 3,996,891.00 | 3,109.00 | 99.9 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,400,000.00 | 7,399,169.00 | 831.00 | 100.0 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 14,609,900.00 | 14,542,900.00 | 67,000.00 | 99.5 |
| Багаж, техник, хэрэгсэл | 1,609,900.00 | 1,600,000.00 | 9,900.00 | 99.4 |
| Урсгал засвар | 13,000,000.00 | 12,942,900.00 | 57,100.00 | 99.6 |
| Томилолт, зочны зардал | 18,192,000.00 | 18,032,000.00 | 160,000.00 | 99.1 |
| Дотоод албан томилолт | 18,192,000.00 | 18,032,000.00 | 160,000.00 | 99.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 94,508,200.00 | 94,072,480.71 | 435,719.29 | 99.5 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 93,422,200.00 | 93,023,417.71 | 398,782.29 | 99.6 |
| Даатгалын үйлчилгээ | 877,100.00 | 877,100.00 | 0.00 | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 147,600.00 | 147,582.00 | 18.00 | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 22,000.00 | 22,000.00 | 50.0 |
| Газрын төлбөр | 17,300.00 | 2,381.00 | 14,919.00 | 13.8 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5,000,000.00 | 4,978,300.00 | 21,700.00 | 99.6 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 5,000,000.00 | 4,978,300.00 | 21,700.00 | 99.6 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 146,325,700.00 | 146,050,700.00 | 275,000.00 | 99.8 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын урсгал шилжүүлэг | 0.00 | -35,000.00 | 35,000.00 | 0.0 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 0.00 | -35,000.00 | 35,000.00 | 0.0 |
| Бусад урсгал шилжүүлэг | 146,325,700.00 | 146,085,700.00 | 240,000.00 | 99.8 |
| ХОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 143,685,700.00 | 143,685,700.00 | 0.00 | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,640,000.00 | 2,400,000.00 | 240,000.00 | 90.9 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,128,233,000.00 | 2,112,323,581.76 | 19,909,418.24 | 99.3 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,128,233,000.00 | 2,112,288,581.76 | 15,944,418.24 | 99.3 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,128,233,000.00 | 2,112,288,581.76 | 15,944,418.24 | 99.3 |
| Бусад орлого | 0.00 | 35,000.00 | -35,000.00 | 0.0 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 0.00 | 35,000.00 | -35,000.00 | 0.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 20,080,000.00 | -20,080,000.00 | - |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 15,240,000.0 | -15,240,000.0 | - |
| АЖИЛЛАГСАДЫН ТОО | 42.00 | 42.00 | 0.00 | 100.0 |
| Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 0.00 | 100.0 |
| Гүйцэтгэх ажилтан | 37.00 | 37.00 | 0.00 | 100.0 |
| Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 | 0.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| I | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 95,197,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 95,197,200.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 92,797,200.00 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 73,824,181.00 |
| 210102 | Нэмэгдэл | 73,824,181.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 9,228,019.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,241,088.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 750,242.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 375,120.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 375,120.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,486,448.69 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,335,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,335,600.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,664,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,664,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,745,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,745,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,400,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 95,197,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,645,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 84,552,200.00 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй бөгөөд нийт **75,871.1** мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэн зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага хүргүүллээ

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 72,871.1 мянган төгрөгийн зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг бусаар, 3,000.0 мянган төгрөгийн зөрчлийг материаллаг алдаагаар тооцсон ба материаллаг зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 23,942.6 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 5.2 Албан шаардлага

**5.2.1.** Татварын ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/266 дугаар тушаалаар байгууллагын даргад 3,085.7 мянган төгрөг, аймгийн Татварын газрын даргын А/58 дугаар тушаалаар байгууллагын 37 албан хаагчдад 69,784.4 мянган төгрөг нийт 72,871.1 мянган төгрөгийн нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг цалингийн зардлын хэмнэлт болон ТЕГ-аас оны эцэст тус зардалд хуваарилсан санхүүжилтээс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2 дахь “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх", 45 дугаар зүйлийн 45.1.5-т "Энэ хуулийн 14.2.12, 16.5.9-т заасны дагуу зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн тогтоосны улмаас орон тоо буурсан бол түүнд ногдох цалин хөлс, бусад урсгал зардлын үлдэгдэл" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Цаашид хууль тогтоомжийг мөрдөж, төсвийн зарцуулаагүй төсвийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлж, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

**5.2.2.** 2022 онд тус зардлаас байгууллагын барилгын конторын засварын ажлын зураг төсвийг ГИ ГА ЛАЙН ХХК-аас гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан 1,500.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч засварын ажил хийгдээгүй бөгөөд барилгын материал нэмэгдсэнтэй холбоотойгоор 2024 онд Жи Эй Икс-д дахин зураг төсөв хийлгэхээр гэрээ байгуулан 3,000.0 мянган төгрөгийг шилжүүлэн гэрээний дагуу зураг төсвийг хүлээн авсан засварын ажлын төсөв батлагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**<u>Шийдвэрлэсэн нь</u>:** Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүллээ.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,
[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Урамшуулал олгосон | 1 | | | | 1 | | - | - | | | | |
| Зураг төсөв үнэ | 1 | 3,000.0 | | | 1 | 3,000.0 | | | | | | |
| **Нийт дүн** | **2** | **3,000.0** | | | **2** | **3,000.0** | | | | | | |